



Монгол Улсын Үндэсний аудитын газар

УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны саналаар
хийсэн аудитын тайлан

Зардлаа бүрэн тайлагнахгүй байна

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
байгууллагын зарим үйл ажиллагаа**



ҮАГ-1/2007/1-ЭА

Улаанбаатар хот
2007 оны 6 дугаар сар

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг

Аудитын менежер Ж.Батсайхан

Ахлах аудитор Ц.Гэрэл

Аудитор С.Андруш

Шинжээч Ш.Энхтайван

2007 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

*Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс*

ҮАГ – Үндэсний аудитын газар

УИХ – Улсын Их Хурал

ШШГЕГ – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

АОУС – Аудитын олон улсын стандарт

Ерөнхий зүйл	2
Бүлэг 1: Өөрийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна.	4
1.1 Үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ	
1.2 Үндсэн бус үйл ажиллагаанаас олсон орлогын зарим хэсгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.	
Бүлэг 2: Худалдан авах үйл ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу төлөвлөөгүй байна	9
Бүлэг 3: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын бүрдүүлэлт, зарцуулалтыг санхүүгийн тайланд нэгтгээгүй байна	12
3.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нэгтгэж, тайлагнаагүй байна.	
3.2 Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны бусад зардал, болзошгүй эрсдэлийн зардалд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө зохицуулалтгүй байна.	
Бүлэг 4: Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна	16
Дүгнэлт	18
Зөвлөмж	19
ШШГЕГ-аас ирүүлсэн санал.....	20
Ерөнхий аудиторовын тушаал.....	21
Товчилсон үгс:	

Ерөнхий зүйл

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг ШШГЕГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар эрсдэлтэй байж болзошгүй гэж тогтоосон зарим асуудалд аудит хийж, үр нөлөөг сайжруулах санал зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- Үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт
- ШШГЕГ-ын 2006 оны худалдан авалт
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал
- Санхүүгийн дотоод хяналтын үр нөлөө.

Аудитаар ШШГЕГ, Нийслэл хот, Багануур дүүрэг, Говьсүмбэр аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шохой тоосгоны нэгдэл, Дарь эхийн хэсэг, Хорих 401, 407, 409, 417, 421, 431, 461 дүгээр ангийн 2006 оны санхүүгийн болон бусад холбогдох материалыг шалгалаа.

3. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, Төрийн хяналт шалгалтын стандарт, эрсдэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад эрсдэлийн аудитын үндсэн элементүүд болох үнэн зөв байдал, зүй зохис болон санхүүгийн хяналттай холбоотой асуудлыг авч үзлээ.

Аудитыг Үндэсний аудитын газрын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг, аудитын менежер Ж.Батсайхан нар удирдаж, Цэрэг, хууль сахиулах байгууллагын багийн ахлах аудитор Ц.Гэрэл, аудитор С.Андруш, шинжээч Ш.Энхтайван нар 2007 оны 5 дугаар сарын 8-наас 6 дугаар сарын 8-ны хооронд хийж гүйцэтгэв.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын талаархи товч танилцуулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь ШШГЕГ, аймаг нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадаас бүрдэж байна.

ШШГЕГ эрхэм зорилгоо “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Тус газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дараахь байдлаар тодорхойлогдсон байна.


- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний бодлого хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах,
- Хорих ял эдлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэгтгэн зохион байгуулах,
- Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, хяналт тавих,
- Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах, ажиллагсдын нийгмийн асуудлыг нааштай шийдвэрлэх.

Бүлэг 1: Өөрийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна

1.1 Үндсэн бус үйл ажиллагааны орлогын даалгаврыг давуулан биелүүлжээ

Монгол Улсын 2006 оны Төсвийн тухай хуулиар ШШГЕГ-ын улсын төсвөөс авах санхүүжилтийг 8,376.6 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 20.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Тус газар 2006 онд төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, үндсэн бус үйл ажиллагааны орлогын даалгаврыг 2,6 дахин буюу 32.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

ШШГЕГ-ын 2006 оны үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүтцийг графикаар үзүүлэв.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэгт хорих ял эдэлж байгаа ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэхийн зэрэгцээ, ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгохоор заасан байна.

Хоригдлуудыг ажлын байраар хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1995 оны 138 болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2002 оны 155 дугаар тогтоолуудаар хоригдлыг ажлын байраар хангах нөхцөл, шаардлага, хорих ангиудын үйлдвэрлэлийн чиглэлийг анги тус бүрээр тогтоосон байна.

Дээрх тогтоолын дагуу ШШГЕГ-ын харъяа 19 хорих байгууллага дэргэдээ үйлдвэрлэл эрхэлж, 2006 онд нийт 1,126.3 сая төгрөгийн борлуулалт хийж, 133.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Эдгээр хорих ангиудын үйлдвэрлэлийн чиглэл, борлуулалтын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараахь хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын нэр	Үйлдвэрлэлийн чиглэл	Борлуулалтын орлого		Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Авдрантын хорих 403-р анги	Ногоон чулуу олборлолт, борлуулалт	32,950.0	31,533.3	95.7
2	Багануур дахь ШШГА	Ногоо, барилгын материал	81,500.0	80,054.1	98.2
3	Амгалангийн хорих 421-р анги	Тахиа, барилгын материал	31,000.0	31,422.7	101.4
4	Баянзүрхийн хорих 407-р анги	Бүх төрлийн оёдол	48,950.0	48,680.7	99.4
5	Дарьтын хорих 433-р анги	Төмс хүнсний ногоо	148,000.0	149,700.9	101.1
6	Зүүнхараа дахь ШШГА	Төмс хүнсний ногоо	123,000.0	123,098.5	100.1
7	Мааньтын хорих 415-р анги	Оёдол, барилга, гэрээт ажил	44,000.0	44,879.5	102.0
8	Мөнгөнморьтын хорих 417-р анги	Ойн цэвэрлэгээ, ойжуулалт	33,900.0	33,313.7	98.3
9	Говьсүмбэр дэх ШШГА	Барилга, гэрээт ажил	9,500.0	8,574.4	90.3
10	Хархорин дахь ШШГА	Газар тариалан, барилгын материал, гэрээт ажил	49,600.0	48,498.0	97.8
11	Хөвсгөл дэх ШШГА	Нүүрс олборлолт, ойн цэвэрлэгээ	43,000.0	43,723.7	101.7
12	Хэнтий аймаг дахь ШШГА	Улаан тоосго, гэрээт ажил	67,000.0	67,335.5	100.5
13	Хорих 409-р анги	Улаан тоосго, бусад	71,500.0	71,559.7	100.1
14	Булган аймгийн хорих 439-р анги	Шохойн чулуу	24,000.0	23,080.8	96.2
15	Дархан-Уул аймаг дахь ШШГА	Гурил, гэрээт ажил	62,000.0	62,018.1	100.0
16	Ховд аймаг дахь ШШГА	Газар тариалан	7,800.0	7,812.5	100.2
17	Хонхорын хорих 431-р анги	Өнгөт хавтан	4,300.0	4,400.0	102.3
18	Шохой тоосгоны нэгдэл	Шохойн чулуу, шохой	146,000.0	149,256.4	102.2
19	Хорих 461-р анги	Гэрээт ажил, бусад	97,000.0	97,391.6	100.4
	Дүн		1,125,000	1,126,334	100.1

Дээрх хүснэгтээс үзэхэд 2006 оны борлуулалтын орлогын төлөвлөгөөг 12 хорих байгууллага 0,1 – 2,3 хувиар давуулан биелүүлж, 7 хорих байгууллага 0,6 – 9,7 хувиар тасалдуулсан байна.

Салбарын хэмжээгээр 2006 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүтээгдэхүүний нэр төрөл, тус бүрээр нэгтгэж харуулбал:

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2006 үйлдвэрлэлийн хэмжээ		Биелэлт хувиар
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Төрөл бүрийн хөшөөний чулуу	м3	1600	1100	68.8
2	Замын хашлага	м3	1500	1600	106.7
3	Хэрэгцээний чулуу	м3	500	620	124.0
4	Цагаан тоосго	мян-шир	1500	1300	86.7
5	Улаан тоосго	мян-шир	1200	1300	108.3
6	Нүүрс	Тн	19000	19200	101.1
7	Шохой	Тн	2500	3000	120.0
8	Шохойн чулуу	Тн	4000	4800	120.0
9	Буталсан чулуу	Тн	650	768	118.2
10	Блок	мян-шир	46500	46800	100.6
11	Гэрийн мод	ком	95	53	55.8
12	Түлээ	м3	1200	1187	98.9
13	Хэрэгцээний мод	м3	650	626	96.3
14	Үзүүр мод	м3	3000	3500	116.7
15	Дүнз	шир	400	600	150.0
16	Зүсмэл	м3	500	542	108.4
17	Зах банз	м3	420	250	59.5
18	Ойжуулалт	га	150	250	166.7
19	Ойн цэвэрлэгээ	м3	1000	1400	140.0
20	Төмс хүнсний ногоо	Тн	960	840	87.5
21	Үр тариа	Тн	45	36	80.0
22	Гурил	Тн	140	56	40.0
23	Өндөг	шир	7000	7473	106.8
24	Хөвөнтэй өмд, цамц	хос	4000	4000	100.0
25	Зуны өмд цамц	хос	5000	5400	108.0
26	Даалимбан өмд цамц	хос	5000	5600	112.0
27	Гудас хөнжил	хос	2000	2100	105.0
28	Ор хөнжлийн даавуу	хос	5400	5900	109.3
29	Хадлан	тн	60	70	116.7

Дээрх нэгтгэлээс үзвэл зарим нэр төрлийн бүтээгдэхүүний төлөвлөгөө тасарсан боловч 2006 оны борлуулалтын орлогын төлөвлөгөө 100,1 хувиар биелсэн байна.

Зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төлөвлөгөө тасарсан нь 2006 онд Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу 2424 ялтан өршөөлд хамрагдан суллагдаж, ажиллах хүч буурснаас шалтгаалжээ.

1.2 Зарим орлогыг бүртгэл, тайланд тусгаагүй байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үйлдвэрлэлийн үйл ажиллагааныхаа ашгаар ажиллагсдын нийгмийн асуудал, ажиллах нөхцөл боломж, ялтны амьдралын орчныг сайжруулах тодорхой ажлууд хийсэн байна.

Тухайлбал, ШШГЕГ-ын харъяа 12 хорих байгууллага конторын болон бусад зориулалтаар 15 барилга, байгууламжийг 89.0 сая төгрөгөөр, 5 хорих байгууллага ялтны болон цагдан хорих байрны зориулалтаар 9 барилгыг 73.0 сая төгрөгөөр, 3 хорих байгууллага ажиллагсдын орон сууцны зориулалтаар 6 - 56 айлын 4 орон сууцны барилгыг 473.6 сая төгрөгөөр тус тус барьж, ашиглалтад оруулсны гадна 86.5 сая төгрөгийн барилгын их засварын ажил гүйцэтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2006 оны үйлдвэрлэлийн зардлын бүтцэд үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй офицер, ахлагч, албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, дотоод албан томилолт, шуудан холбоо, тээвэр шатахуун, үйлдвэрлэл эрхэлж байгаа цех тасаг, үйлдвэрүүдийн түлш халаалт, гэрэл цахилгааны зардал, түүхий эд материалын зардал багтаж байна.

Зарим барилга байгууламж, бүтээгдэхүүний өртөгт хоригдлын ажлын хөлсийг бүрэн оруулж тооцохгүй байгаа нь өртөг зардал буурахад нөлөөлсөн байна. Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам зэрэг байгууллагуудтай зөвшилцөн гаргасан ШШГЕГ-ын даргын 2006 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, үнэлгээ”-ний журамд хөдөлмөрийн хөлсөнд хуулийн дагуу ногдох шагналын хоног олгож байхаар заасантай холбоотой байна.

Тухайлбал, Улаанбаатар хотод баригдсан 32 айлын орон сууцыг барих төсвөөр 1 ам.метр талбай 458,5 мянган төгрөг буюу нийт төсөвт өртөг 645,6 сая төгрөг байхад гүйцэтгэлээр 1 ам.метр талбай 130,7 мянган төгрөг буюу нийт өртөг 184,0 сая төгрөг болсон байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны арилжааны банкинд хадгалагдаж буй харилцах дансны үлдэгдэлд 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тооцсон хүү 35,786.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгалгүй зарцуулсан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан нь иж бүрэн, үнэн зөв байх зарчимтай нийцэхгүй байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба дээрх мөнгөнөөс эд хогшил авч, урсгал зардалд зарцуулсан мөртлөө энэ хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг тайлан тэнцэлд “Үнэ төлбөргүй авсан” гэж бүртгэсэн байна.

Тус алба иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад “өр зээлгүй” гэсэн тодорхойлолтыг 1000 төгрөгөөр олгодог бөгөөд сард дунджаар 500.0 мянган төгрөг, жилд 6.0 сая төгрөгийн орлого олдог байна. Энэ орлогыг урамшууллын тайланд тусган зарцуулсан байна.

Говьсүмбэр аймаг дахь Хорих 425 дугаар ангийн зарим үйл ажиллагаатай танилцах явцад ялтныг гэрээгээр ажил гүйцэтгүүлсний орлогыг бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй зөрчил илэрлээ.

Тухайлбал, тус ангийн хоригдлуудын байршлын мэдээнд 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдөр жирийн дэглэмтэй 9 хоригдол Хар айраг дахь жоншны хувийн уурхайд гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа гэж тэмдэглэжээ. Нэг ялтныг хоногт 2500 төгрөгөөр тооцон ажилд гаргасан гэж үзвэл сард 495.0 мянган төгрөгийн орлого олох тооцоо гарч байна. Гэтэл тус ангийн 2006 оны санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан гэрээгээр 2 удаа ажил гүйцэтгэсний орлого нийт 618.0 мянган төгрөг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2006 онд 30 айлын орон сууцны барилгыг засварлаж, ашиглалтад оруулахад хоригдлын хүчийг ашигласантай холбоотой хоригдлыг гэрээгээр гадагш ажиллуулах боломж хязгаарлагдмал байжээ.

Бүлэг 2: Худалдан авах үйл ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу төлөвлөөгүй байна

Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор баталсан “Бараа ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”-ын 2 дугаар бүлэгт заасны дагуу захиалагч байгууллага тухайн жилийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх график, төлөвлөгөө гаргаж, түүнд тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр тендерийн хороо байгуулах, тендерийн бичиг баримт бэлтгэж, батлуулах, тендерийн урилгыг зарлан мэдээлэх, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх зэрэг ажлуудыг тодорхойлох ёстой.

Үүнээс гадна худалдан авах ажиллагааны явцын тайланд худалдан авах ажиллагааны хөрөнгийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны сонгосон журам, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх хугацаа, тэдгээрийн санхүүжилт зэрэг ажлын хэрэгжилтийн байдлыг тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр тодорхойлох шаардлагатай.

УИХ-аас ШШГЕГ-ын 2006 оны үйл ажиллагааны зардал болон хөрөнгө оруулалтын хэмжээг дараахь байдлаар баталсан байна:

№	Эдийн засгийн ангилал	Дүн
1	Цалин хөлс, НДШ, эдгээртэй адилтгах зардал	3,916,607.2
7	Бичиг хэрэг, шуудан холбоо, ном хэвлэл	114,975.3
9	Түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус	935,815.5
10	Тээвэр, шатахуун	382,424.8
13	Албан томилолт	70,359.5
16	Хичээл сургалт, эрдэм шинжилгээний ажил	47,432.5
18	Эд хогшил худалдан авах	50,000.0
19	Нормын хувцас, зөөлөн эдлэл	784,977.4
20	Хоол	1,888,000.0
21	Эм	144,600.9
22	Урсгал засвар	40,000.0
23	Төлбөр хураамж	21,568.1
27	Туслах үйл ажиллагааны орлого	20,100.0
28	Төсвөөс санхүүжих	8,376,661.2
29	Хөрөнгө оруулалтын зардал	212,000.0
30	Дүн	8,588,661.2

ШШГЕГ 2006 оны худалдан авах ажиллагааны график, төлөвлөгөө, явцын тайланг гаргаж, баталгаажуулаагүй байна.

Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас бусад худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан төсөв, гүйцэтгэл зэрэг мэдээллийг худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр гаргахад цаг хугацаа нилээд зарцууллаа.

ШШГЕГ дээрх хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны санхүүжилтээс зөвхөн төвлөрсөн хангалтаар олгодог нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Дээрх тендер шалгаруулалтыг явуулснаар зардлыг төлөвлөсөн хэмжээнээс 60,1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Нээлттэй тендерээр гүйцэтгэгч нь шалгараагүй бараа, ажил, үйлчилгээнд хязгаарлагдмал тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан дүгнэсэн байна.

УИХ-аас ШШГЕГ-ын 2006 оны хөрөнгө оруулалтад 212,0 сая төгрөг батлагдсан бөгөөд хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу сонгох ёстой байсан.

2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 50,0 сая төгрөгөөр хорих ангиудад шуурхай алба, эмнэлгийн үйлчилгээнд зориулж УАЗ фургон автомашин худалдаж авахаар дээрх зөвлөмжид заасан байна. Гэтэл энэ зөвлөмж бүрэн хэрэгжээгүй бөгөөд худалдаж авсан автомашинуудыг хүснэгтээр харуулбал:

№	Автомашины марк	Хорих ангийн дугаар	Тоо ширхэг	Үнэ (мянган төгрөг)
1	Митсубиши Пажеро жийп	Дарь эхийн хэсэг	1	7335,0
2	Ниссан террано жийп	Хорих 429-р анги	1	7962,5
3	Портер /ачааны автомашин/	Хорих 405-р анги	1	4500,0
4	Асио /дунд оврын автобус/	Хорих 429-р анги	1	7000,0
5	Грейс микроавтобус	Хорих 403-р анги	1	5500,0
6	Делика /микроавтобус/	Хорих 439-р анги	1	9780,5
7	УАЗ Фургон	Хорих 401-р анги	1	7922,0
	Дүн		7	50000,0

Дээрх автомашинуудыг Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлгүй ШШГЕГ-ын даргын 2006 оны А/185 дугаар тушаалыг үндэслэн худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.4-д “Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэж заасныг зөрчсөн байна.

Бүлэг 3: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын бүрдүүлэлт, зарцуулалтыг санхүүгийн тайланд нэгтгээгүй байна

3.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нэгтгэж, тайлагнаагүй байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 82 дугаар зүйлд шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас урьдчилан гаргуулж, шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлэн зарцуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусвар болоход зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, буцаан олгохоор заажээ.

Мөн энэ зүйлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно гэж зааснаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 208 дугаар тушаалаар “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох” журмыг баталжээ.

Дээрх журмаар шийдвэр гүйцэтгэгч зардлын хэмжээг тогтоож төлбөр авагчаас урьдчилан гаргуулж, хот дотор 24 цаг, хөдөө орон нутагт 72 цагийн дотор шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушааж, шийдвэр гүйцэтгэлийн алба, төлбөр авагч хоёрын хооронд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гаргуулах тухай” гэрээ байгуулж байна.

Аудитын явцад ШШГЕГ-ын харъяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадаас Нийслэл, Багануур дүүрэг, Говьсүмбэр аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадыг сонгон шийдвэр гүйцэтгэлийн зардлын бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналын байдалд аудит хийлээ.

2006 онд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба нийслэлийн 7 дүүргийн төлбөр авагч 2118 иргэн, хуулийн этгээдтэй хийсэн шийдвэр гүйцэтгэх гэрээний дагуу 3.0-50.0 мянган төгрөгийг бэлнээр авч, 39.2 сая төгрөг төвлөрүүлжээ.

Энэ хөрөнгөөс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой 8 төрлийн зардалд 33.8 сая төгрөг зарцуулж, тайлант хугацааны эцэст биелээгүй 458 гүйцэтгэх хуудсанд ногдох 8.54 сая төгрөг үлджээ.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дуусвар болох үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд урьдчилан авсан мөнгөний тайланг анх хураан авсан мөнгөний дүнд тохируулан тайлагнаж байгаа нь уг мөнгийг тухайн гүйцэтгэх ажиллагаанд бүрэн зарцуулсан гэж үзэх үндэслэл муутай байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2006 оны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын 55.6 хувийг эзэлж байгаа шатахууны зардалд 18,769.6 мянган төгрөг зарцуулснаар тайлагнасан байна. Аудитын явцад энэ зардлыг анхан шатны баримтаар

тулган баталгаажуулахад (жолооч нарын замын тооцооны хуудас) 10,773.9 мянган төгрөг зарцуулсан тооцоо гарч байна. Үлдсэн 7,995.7 мянган төгрөгийг шатахуун нэрээр үндсэн баримтгүй зарцуулжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Анхан шатны баримтгүй зарцуулсан 7,995.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага бичлээ.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын мөнгөнөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заагаагүй албаны засвар тохижилт, талархал өргөмжлөл зэрэг зардал гаргасан нь нийт зардлын 3.4 хувийг эзэлж байна.

Багануур дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба 2006 онд 282 иргэн, хуулийн этгээдтэй шийдвэр гүйцэтгэх гэрээгээр 1587.0 мянган төгрөгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал төвлөрүүлж, 1458.0 мянган төгрөгийг зарцуулсны дотор шуудан холбооны зардал 703.5 мянган төгрөг буюу 48.2 хувийг, албадан дуудлага худалдаа, үнэлгээний зардал 355.0 мянган төгрөг буюу 24.3 хувийг, бичиг хэрэг 199.5 мянган төгрөг буюу 13.7 хувийг, шатахууны зардал 145.0 мянган төгрөг 9.9 хувийг тус тус эзэлж байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба 2006 онд зарцуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын 55.6 хувийг тээвэрт, Багануур дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 48.2 хувийг шуудан холбоонд, Говьсүмбэр аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 68.8 хувийг эд хөрөнгө хураах битүүмжлэх, хадгалахад зарцуулснаар тус тус тайлагнаснаас үзвэл зардлын тайланг ямар ч байдлаар тайлагнах бололцоотойг харуулж байна.

ШШГЕГ өөрийн харъяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын тайланг авч нэгтгээгүйгээс салбарын хэмжээний тайлан гараагүй байна.

Тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд хэдэн төгрөг төвлөрч, хэрхэн зарцуулж байгаа талаар нэгдсэн мэдээ, тайлан алга байна.

3.2 Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны бусад зардал, болзошгүй эрсдэлийн зардалд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө зохицуулалтгүй байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэх тухай хуулийн 83.1-д шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн дүнгээс 0.5-10 хүртэл хувиар урамшуулахаар заасан байна.

Мөн хуулийн 83.2-т уг урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусвар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83.3-т урамшуулал олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд 2002 оны 208 дугаар тушаал гаргаж, “Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах” журмыг баталжээ.

Урамшуулал тооцох, хуваарилах хувь хэмжээ

Шийдвэр гүйцэтгэлийн үнийн дүн (сая төг)	Шийдвэр гүйцэтгэлийн үнийн дүнгээс суутгах хувь	Үүнээс		
		Шийдвэр гүйцэтгэгчид олгох хувь	Болзошгүй эрсдэлийн санд төвлөрүүлэх хувь	Шийдвэр гүйцэтгэлийн бусад үйл ажиллагаанд төвлөрүүлэх хувь
0-1.0	10	5.5	1	3.5
1.0-5.0	8.5	4		
5.0-10.0	8	3		
10.0-25.0	7.5	2.5		
25.0-50.0	7	2		
50.0-75.0	6.5	1.5		
75.0-100.0	5.5	1		
100.0 –аас дээш	5	0.5		

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн үнийн дүнгийн шийдвэр гүйцэтгэлийн бусад үйл ажиллагаанд төвлөрүүлэх 3.5 хувь, болзошгүй эрсдэлийн санд төвлөрүүлэх 1 хувь, бүгд 4,5 хувийг ШШГЕГ-т төвлөрүүлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадын санхүүжилтэд зарцуулж байна.

“Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах” журмын 6.7-д аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албаны шийдвэр гүйцэтгэлийн бусад үйл ажиллагаа болон болзошгүй эрсдэлийн санд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг ШШГЕГ-ын даргын тушаалаар зохицуулахаар заасан боловч Гүйцэтгэлийн бусад үйл ажиллагаа болон болзошгүй эрсдэлийн санд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг зарцуулах журам өнөөг хүртэл гараагүй байна.

2006 оны урамшууллын орлогыг ШШГЕГ-ын харъяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад зардал болон болзошгүй эрсдэлийн зардалд зарцуулсан байдлыг харуулбал:

(сая төгрөг)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны бусад зардалд	481.5	378.4	307.9	552.0
2	Болзошгүй эрсдэлийн санд	127.2	111.4	33.0	205.6
	Дүн	608.6	489.7	340.9	757.6

Аудитад хамрагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадаас 2006 оны урамшууллын орлогыг хуваарилсан байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Бодитой гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэл	Нийт урамшуулал	Үүнээс ШШГЕГ-т (сая. төгрөг)			Шийдвэр гүйцэтгэгчид
				3.5%	1.0%	Дүн	
1	Нийслэлийн ШШГА	7141.1	430.5	230.8	65.9	297.7	129.0
2	Багануур дахь ШШГА	119.6	10.3	4.0	1.1	5.1	5.2
3	Говьсүмбэр дэх ШШГА	15.6	1.2	0.5	0.2	0.7	0.5
	Дүн	7276.3	442.0	235.3	67.2	303.5	134.7

ШШГЕГ-т төвлөрсөн дээрх орлогоос шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадын цалин, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас бусад үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж, салбарын хэмжээнд нэгдсэн санхүүгийн тайлан гаргаж байна.

Энэ санхүүжилт нь Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хувьд 2006 оны нийт зардлын 32.3 хувийг эзэлж байна.

Бүлэг 4: Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна

ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, бодлого, төлөвлөлт зохицуулалтын газар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бусад эрхийн актын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналд өдөр тутмын хяналт тавьж байна.

Нягтлан бодох бүртгэлийн дээрх бодлого, журмууд хэдийгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Монгол Улсын Сангийн сайдын 2000 оны 116 дугаар тушаал, 1999 оны 215 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын дансны үлгэрчилсэн заавар болон Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, санхүүгийн тайлангийн маягт зэрэг хууль, тогтоомжуудад үндэслэн бэлтгэгдсэн боловч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Тухайлбал, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал, бүтээгдэхүүний өртөг тооцох заавар, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан гаргах журам, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал, Санхүүгийн нэгдсэн тайлан, маягт түүнийг нөхөх заавар, Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүтээгдэхүүний нэгтгэсэн тайлан гаргах журмыг тус тус батлан гаргажээ.

ШШГЕГ-ын Хяналт шалгалтын хэлтэс Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 1995 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, ШШГЕГ-ын даргын 2003 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод хяналт шалгалтын журам”-ын хүрээнд тус газрын дотоодын хяналт шалгалтын ажил, үүргийг эрхлэн гүйцэтгэж байна.

Тус хэлтсийн зорилго, чиг үүрэг нь салбарын төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаанд иж бүрэн, төрөлжсөн, хэсэгчилсэн шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, шуурхай явуулахад чиглэсэн байна.

Хяналт шалгалтын хэлтэс 2006 онд төлөвлөгөөт шалгалтыг бүрэн хийсний гадна удирдлагын захиалга, даалгавраар 3 шалгалт хийж, дүнг удирдлагад тухай бүр танилцуулж байжээ.

Тухайлбал, төлөвлөгөөт шалгалтад төлөвлөгөөний дагуу Дорноговь, Баянхонгор, Увс, Өвөрхангай, Говь Алтай, Дархан Уул аймаг, Багануур дүүрэг дэх ШШГА, Хорих 401 дүгээр анги зэрэг мал бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хорих ангиуд хамрагдсан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн, түүнийг залруулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Дүн
2	Шалгалтын хугацаанд газар дээр нь арилгасан	16,898,929
3	Хугацаатай үүрэг өгч, засч, залруулсан	11,151,400
4	Засч залруулж арилгуулаагүй	200,000
	Нийт зөрчлийн дүн	28,250,329

Шалгалтын дүнд 8 актыг 30 хүнд хамруулан тавьж 3978.9 мянган төгрөгийг төлүүлсэн байна. Түүнчлэн 24271.4 мянган төгрөгийн 12 зөрчлийг шалгалтын хугацаанд болон хугацаатай үүрэг өгч арилгуулжээ.

Шалгалтын хугацаанд 10 хууль, Хууль зүй дотоод хэргийн сайдын 21 тушаал, Засгийн газрын 23 тогтоол, ШШГЕГ-ын даргын 62 тушаалын хэрэгжилт, үр дүнг хамруулан шалгалт хийжээ.

Тус газрын Дотоодын хяналт шалгалтын хэлтэс ийнхүү алба, хорих газруудын түвшинд хяналт шалгалт хийж, тодорхой үр дүнд хүрч байна. Цаашид үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлэн эрсдэл бүхий үйл ажиллагаа, газар хэлтсүүдийг хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хамруулах нь зүйтэй юм.

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг бүртгэл, тайланд бүрэн тусгах, түүнд тавих хяналтыг сайжруулснаар орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна.
- Худалдан авах үйл ажиллагааг зохих журмын дагуу нарийн төлөвлөөгүй байна.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.
- Дотоодын хяналт шалгалтын үйл ажиллагааг хязгаарлагдмал хүрээнд явуулж байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын төвлөрүүлэлт зарцуулалт, буцаан олголтын талаар нэгдсэн тайлан гаргаагүй, энэ төрлийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн нэгдсэн тайланд тусгаагүй байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн үнийн дүнгээс олгох урамшууллаас ШШГЕГ-т төвлөрүүлсэн хөрөнгийг зохицуулах журам гаргаж мөрдөөгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ШШГЕГ-ын дарга, хурандаа Д.Батжаргалд зөвлөж байна.

1. Үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих дотоодын хяналт шалгалтыг сайжруулж, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох.
2. Хууль, тогтоомжид заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн батлагдсан төсөвтэй уялдуулан боловсруулж, баталгаажуулан нийтэд мэдээлж байх.
3. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа түүний төсөвт өртгийг Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан босго үнэтэй харьцуулан худалдан авах ажиллагаанд баримтлах журмыг зөв сонгож, Сангийн сайдын 2007 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журам”-ын дагуу тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг хийж хэвшүүлэх.
4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу үл хөдлөх болон хөдлөх үндсэн хөрөнгө худалдаж авахдаа зохих зөвшөөрөл, шийдвэрийг авч байх.
5. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын төвлөрүүлэлт, зарцуулалт, нөхөн олголтын талаархи мэдээллийг нэгтгэж, ажил гүйлгээг бүртгэлд тусгаж, тайлагнах
6. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журмын 6.7-д заасны дагуу шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны бусад зардал, болзошгүй эрсдэлийн зардалд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг зарцуулах тухай журмыг баталж мөрдөх
7. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын 2006 оны 388, 32 дугаар тушаалд заасан нөхцөл, шаарлагын дагуу шинэчлэн боловсруулж, баталгаажуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгох.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР**

210646, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 31-31-04, Факс: 32-99-33

2007-08-21 № 4/1512

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР
ТАНАА

Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд дурьдсан аудитын дүн, дүгнэлттэй санал нэг байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх болно.

ДАРГА,
ХУРАНДАА



Д.БАТЖАРГАЛ